ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 08 өдөр Дугаар А/125 Арвайхээр сум

Хог тээврийн машин, нийтийн тээврийн автобусыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хог тээврийн машин, нийтийн тээврийн автобусыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Гал-Эрдэнэ (хотын Захирагчийн албаны ерөнхий менежер)
Нарийн бичгийн дарга: Ц.Наранбадам (хотын Захирагчийн албаны мэргэжилтэн)
Гишүүд: Д.Сүх-Өлзий (“Арвайхээр тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал)
Д.Доржхорлоо (Арвайхээр тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын менежер)
Ц.Янжмаа (Арвайхээр тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч)
Х.Энхжаргал (Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал)
Б.Түмэнбаяр (Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч)
П.Энхтайван (Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын жолооч)
Д.Сосорбарам (Иргэний төлөөлөл)

2.Хог тээврийн машин, нийтийн тээврийн автобусыг хүлээн авах ажлыг зохион байгуулж акт үйлдэн холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх ажлыг хэсгийн ахлагч (Б.Гал- Эрдэнэ), ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx

82411299